



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 34

Мандалговь

Г Ундсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх, акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ Нь:


Нэг. Дэрэн сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 978,500 /есөн зуун далан найман мянга таван зуу/ төгрөгийн балансын үнэтэй, 873,930 /найман зуун далан гурван мянга есөн зуун гуч/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй нэгдүгээр хавсралтад дурьдсан төмөр хашааг Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлэх, 265,413 /хоёр зуун жаран таван мянга дөрвөн зуун авсан гурав/ төгрөгийн балансын үнэтэй, 209,175 /хоёр зуун есөн мянга нэг зуун далан тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хоёрдугаар хавсралтад дурьдсан шон болон хашааг акталж данснаас хасахыг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр.Дэрэн сумын Цэцэрлэгийн эрхлэгч Р.Нэргүй, Дэрэн сумын Засаг дарга Н.Мядагмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23.ний өдрийн 34 тогтоолын нэгдүгээр хавсралт

**Дээрн сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийг балансаас,
балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Хамжийн тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуриатлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Хашаа	2007-07-01	ш	30	21,690	650,700	65,070
2	Шон	2007-01-07	ш	14	4,217.50	59,045	5,905.20
3	Төмөр хашаа	2018-12-31	ш	19	13,437.78	255,317.82	31,915.44
Нийт дүн						978,500.76 /есөн зуун далан найман мянга таван зуу төгрөг/ далан зургаан мөнгө	104,570.4 /нэг зуун дөрвөн мянга таван зуун далан төгрөг/ дөрвөн мөнгө
						873,930.36 /найман зуун далан гурван мянга есөн зуун гучин төгрөг/ гучин зургаан мөнгө	

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23.ний өдрийн 34 тогтоолын хоёрдугаар хавсралт

**Дэрэн сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Хамгийн шийдвэрийн жонжийн тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хурумтлагдах элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Шон	2010-02-09	ш	1	30,000	30,000	28,000
2	Төмөр хашаа	2018-12-31	ш	301	3,775.06 3,775.09	113,251.80 3,775.09	14,155.20 471.84
3	Хашаа	2018-12-31	ш	81	5,934.77 5,934.83	47,478.16 5,934.83	4,748.16 741.84
4	Төмөр хашаа	2018-12-31	ш	8	8,121.74	64,973.92	8,121.60
Нийт					265,413.8 /хоёр зуун жаран таван мянга дөрвөн зуун арван гурван төгрөг/ найман мөнгө	56,238.64 /тавин зургаан мянга хоёр зуун гучин найман төгрөг/ жаран дөрвөн мөнгө	209,175.16 /хоёр зуун есөн мянга нэг зуун далан таван төгрөг/ арван зургаан мөнгө